



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ

13335 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Нам Ян Жугийн гудамж 32/1, Утас: 45 39 94,
Факс: (976-11) 45 86 99, И-мэйл: info@ncdd.gov.mn,
Вэбсайт: www.ncdd.gov.mn

2018-10-31 № 11/1051
танай _____-ны № _____-т

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ

Зөвлөмж хүргүүлэх тухай

Улирлын томуугийн эсрэг вакцинаар 2018-2019 оны томуугийн улирлыг угтуулан эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, жирэмсэн эмэгтэйчүүд, өндөр настан, Улаанбаатар хотын зарим цэцэрлэгийн хүүхдүүдийг дархлаажуулах ажлын хүрээнд дараах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана уу.

1. Вакцин хийхийн өмнө эмч, сувилагч нар томуугийн вакцины зааврыг уншиж судалсан байх.
2. Иргэдэд вакцин хийхийн өмнө эмчийн үзлэгийг нягт нямбай хийж, эрүүл гэж үзсэн тохиолдолд вакцин хийнэ. Эмчийн үзлэг болон вакцин тариулсан тухай тэмдэглэгээг эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэнэ.
3. Вакцин хийлгэсэн хүмүүс нь тухайн вакцины найрлаганд орсон вирусын хэв шинжээр үүсгэгдсэн томуугаас сэргийлэгдэх бөгөөд вакциныг хийснээс хойш 14 хоногийн дотор дархлал тогтоно.
4. Дархлаажуулалтын дараа илрэх урвал, хариу арга хэмжээний талаар иргэд, цэцэрлэгийн хүүхдийн эцэг, эх асран хамгаалагч нарт танилцуулан вакцин хийлгэхийг зөвшөөрсөн тухай гарын үсэг зуруулж дархлаажуулна.
5. Вакцины зааварт тусгагдсан эсрэг заалттай, хүмүүст вакцин тарихгүй:
 - Халдварт өвчнөөр өвдөөд 1 сар болоогүй;
 - Товлолын болон бусад вакцин (менингит, гепатит В)-д хамрагдаад 1 сар болоогүй;
 - Сайн дурын үндсэн дээр ХӨСҮТ-ийн сайн дурын дархлаажуулалт болон хувийн хэвшлийн байгууллагаар улирлын томуугийн эсрэг вакцинд хамрагдсан;
 - Эцэг, эх, асран хамгаалагч нь вакцин хийлгэхээс татгалзсан хүүхэд,

6. Жирэмсэн эмэгтэйчүүдэд жирэмсний аль ч үед уг вакциныг хийж болно.
7. Задалсан вакциныг хэрэглэх журам, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж ажиллана. Вакцин задалсан огноо, цаг, минутыг флакон дээр зайлшгүй тэмдэглэх.
8. Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн сэжигтэй тохиолдол илэрсэн үед тухайн мэдээллийг шуурхай дамжуулах, яаралтай хариу арга хэмжээ авах.
9. Сайн дурын дархлаажуулалтанд хамрагдах иргэдийн төлбөрийг дараах дансанд тушаалган, төлбөр тушаасан баримтыг нэгтгэн Дархлаажуулалтын албанд мэдээ тайлангийн хамт ирүүлнэ.
 - Банкны нэр: Төрийн сан банк
 - Хүлээн авагч байгууллага: Эрүүл мэндийн яам
 - Дансны дугаар: 100900020001

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Д.НЯМХҮҮ